

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ДАЙЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Дайчилгааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

Дайчилгааны тухай хуульд өөрчлөлт  
оруулах тухай хуулийн төсөл

НҮБ-ын Хүний эрхийн хорооноос үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд зайлшгүй бус, тохиромжгүй хязгаарлалт тогтоохгүй байхыг зөвлөдөг.<sup>1</sup>

Манай улсын хувьд Онц байдлын тухай хуульд заасны дагуу олон нийтийн онц байдал тогтоосон хугацаанд мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоо, эсхүл онц байдлыг цуцлах хүртэл үйл ажиллагааг нь зогсоох нэмэлт онцгой арга хэмжээ тогтоож болох зохицуулалт үйлчилдэг. Өөрөөр хэлбэл мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоох нэмэлт арга хэмжээг авч болно эсхүл авахгүй ч байж болно гэсэн агуулгаар тусгасан байдаг.

Гэтэл Дайчилгааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь заалтад улсын дайчилгаа явуулахад хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зохицуулах үйл ажиллагааг үндсэн арга хэмжээ болгон хэрэгжүүлэхээр заасан.

Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.”, “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй” байхаар тус тус заасан. Иймд Дайчилгааны тухай хуулийн дээрх заалтыг хүчингүй болгохоор тусгалаа.

## ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

---

<sup>1</sup> Үндсэн хууль манай сургуульд. НҮБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар. 2022 он 155 дугаар хуудас